

ОРХОН АЙМГИЙН ШИЛДЭГ АЖ АХҮЙН НЭГЖ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ийг шалгаруулахад энэхүү журмыг мөрднө.

1.2. Энэхүү журмын зорилго нь орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсан, шинээр ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, сурталчилан таниулахад оршино.

1.3. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан төрийн болон орон нутгийн өмчин оролцоогүй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай 5 хүртэлх аж ахуйн нэгжийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн дараах төрлүүдээр жил бүр шалгаруулна. Үүнд:

- Шилдэг бүтээн байгуулагч аж ахуйн нэгж- 1
- Нийгмийн салбарын шилдэг хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж- 1
- Шилдэг дунд үйлдвэр, үйлчилгээ зэрхлагч аж ахуйн нэгж- 1 /50-200 хүртэлх ажиллагчидтай /
- Шилдэг жижиг үйлдвэр, үйлчилгээ зэрхлагч аж ахуйн нэгж- 1 /10-50 хүртэлх ажиллагчидтай /
- Шилдэг бичил үйлдвэр, үйлчилгээ зэрхлагч аж ахуйн нэгж- 1 /10 хүртэлх ажиллагчидтай /

1.4. Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ээр шалгаруулах асуудлыг ажлын хэсгийн саналыг үндэслэн аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ээр аймгийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж хамрагдана.

Гурав. Тавигдах шаардлага

3.1. Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ийн шалгаруулалтанд оролцох хүсэлтэй аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ нь тогтвортажсон, сүүлийн 3 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа, орон нутагт татвар төлөгч байх ба холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамжаа төлсөн, өр төлбөргүй байх;

3.1.2. Ажиллагчидaa эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамруулж, шимтгэлийг тогтмол төлсөн, зөрчилгүй байх;

3.1.3. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа эрхэлдэг, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй орчныг бүрэн шийдвэрлэсэн байх;

3.1.4. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүй байх;

3.1.5. Шинэ үйлчилгээ, дэвшилтээ техник технологи, инноваци нэвтрүүлсэн байх.

Дөрөв. Шалгуур үзүүлэлт

4.1. Орхон аймгийн "Шилдэг бүтээн байгуулагч аж ахуйн нэгж"- ээр тодорхойлогдож байгаа аж ахуйн нэгж нь энэ журмын 3-т заасан шаардлагаас гадна дараах шалгуур үзүүлэлт хангасан байна. Үүнд:

4.1.1. Орон нутгийн нийгэм, здийн засаг, дэд бүтцийн салбарын хөгжилд шинэ жишиг болохуйц үзүүлэлт, үр нөлөөтэй тухайн жилд бий болсон бүтээн байгуулалт байх;

4.1.2. Тухайн бүтээн байгуулалт нь ашигласан техник, технологи нь холбогдох норм, дүрэм, стандартыг хангасан, эрчим хүч хэмнэсэн, байгаль орчинд зэлтэй байх;

4.1.3. Шинээр ажлын байр бий болгосон байх.

4.2. Орхон аймгийн "Нийгмийн салбарын шилдэг хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж"- ээр тодорхойлогдож байгаа аж ахуйн нэгж нь энэ журмын 3-т заасан шаардлагаас гадна дараах шалгуур үзүүлэлт хангасан байна. Үүнд:

4.2.1. Орон нутгийн нийгмийн хөгжилд шинэ жишиг болохуйц үзүүлэлт, үр нөлөөтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт байх;

4.2.2. Тухайн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нь улс, орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэсэн, холбогдох норм, дүрэм, стандартыг хангасан байх;

4.2.3. Тухайн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нь улс, орон нутгийн тесев, тесэл, хетэлбер, териин бус байгууллага, хувийн хэвшлийн аль ч хөрөнгө оруулалтаар хийгдсэн байж болно.

4.3. Орхон аймгийн үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж нь энэ журмын 3-т заасан шаардлагаас гадна дараах шалгуур үзүүлэлт хангасан байна. Үүнд:

4.3.1. Аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, худалдаа, үйлчилгээний төрөл цар хүрээ нь жил дараалан есслөн байх;

4.3.2. Үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжтэй, холбогдох стандартуудыг дагаж мөрддөг байх;

4.3.3. Үйлдвэрлэлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ техник, тоног төхөөрөмж, дэвшилтээ арга технологи инновацийг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийж, тодорхой үр дүнд хурсэн байх;

4.3.4. Аж ахуйн нэгж нь 200 хүртэлх ажиллагчидтай байх;

4.3.5. Нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг дээшлүүлэхэд идэвх санаачлагатай оролцсон байх.

Тав. Бүрдүүлэх бичиг баримт , шалгаруулах зарчим

5.1. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 5 хүртэлх аж ахуйн нэгжийг Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ээр жил бүр шалгаруулж, шагналыг "Эрдэнэт хотын өдөр"-ийг тохиолдуулан гардуулна.

5.2. Аж ахуйн нэгж нь шалгаруулалтанд дараах бичиг баримтыг бүрдүүлэн жил бурийн 11 дүгээр сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ.

5.2.1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

5.2.2. Аж ахуйн нэгжийн тайлан /сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтээр/

5.2.3. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын танилцуулга

5.2.4. Үйл ажиллагаа эрхэлж буй газрын сум, багийн Засаг даргын тодорхойлолт

5.2.5. Татвар болон Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт

5.3. Нэр дэвшигчдийн ирүүлсэн баримтыг ажлын хэсэг танилцан судалж журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, хамгийн өндөр үзүүлэлт бүхий 5 хүртэлх аж ахуйн нэгжийг шалгаруулан аймгийн Засаг даргад уламжилна.

5.4. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, холбогдох байгууллагуудаас лавлагaa, дүгнэлт авах, иргэд, хэрэглэгчдийн санал, сэтгэгдлийг судлах ажлыг зохион байгуулна.

5.5. Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ийн шагналыг жилд 1 удаа олгоно.

5.6. Аймаг, хотын тэгш ойг тохиолдуулан "Шилдэг аж ахуйн нэгж"-ээр шалгаруулах аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэн шагнаж болно.

5.7. Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ээр 3 жил дотор дахин тодорхойлохгүй.

Зургаа. Шилдэг аж ахуйн нэгжийг урамшуулах

6.1. Орхон аймгийн "Шилдэг аж ахуйн нэгж"-ээр шалгарсан байгууллагад тус бүр аймгийн Засаг даргын батламжилсан гэрчилгээ, аймгийн шилдэг аж ахуйн нэгжийн цом, 3.0 сая төгрөгийн мөнгөн шагналаар шагнана.

6.2. Аймгийн шилдэг аж ахуйн нэгжийн шагнал нь "Шилдэг аж ахуйн нэгж", "Шилдэг бүтээн байгуулалт" гэсэн логотой байна.

6.3. Орхон аймгийн шилдэг аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүн, үйлчилгээний сурталчилгаандаа аймгийн шилдэг аж ахуйн нэгж, шилдэг бүтээн байгуулалт логог хэрэглэхийг зөвшөөрнө.

6.4. Шилдэг аж ахуйн нэгжийн мэдээллийг аймгийн вэб сайт болон хотын лавлах номонд үнэ төлбөргүй байршуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сурталчилгааны самбарт жилд хоёр удаа үнэ төлбөргүй сурталчилна.

Долоо.Бусад зүйл

7.1. Шилдэг аж ахуйн нэгжээр шалгарсан байгууллага үйлчлүүлэгчийн эрх ашгийг ямар нэг байдлаар хэндсөн, чанаргүй бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хэрэглэгчдийг хохироосон нь холбогдох төрийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах олон нийтийн байгууллагын хяналт шалгалтаар тогтоогдсон бол Орхон аймгийн шилдэг аж ахуйн нэгж, шилдэг бүтээн байгуулалт логог хэрэглэх эрхийг цуцална.

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	<ul style="list-style-type: none">-Хотын захирагчийн албаны дарга-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга-Баян-Өндөр сумын Засаг даргын орлогч-Жаргалант сумын Засаг даргын орлогч-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга-Татварын хэлтсийн дарга-Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга-Аймгийн ажил олгогч зэдийн холбооны Тэргүүн
Нарийн бичгийн дарга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, ерхийн аж ахуй, жижиг бизнесийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн

-ОоO-